



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 09 өдөр

Дугаар

A/104

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 94 дүгээр цэцэрлэгийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны A/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 5 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эцэг эхчүүд, багш ажилчдаас хандивласан нийт 7,724,900.00 (долоон сая долоон зуун хорин дөрвөн мянга есөн зуун) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Баянгол дүүргийн 94 дүгээр цэцэрлэг (Б.Алтаннавч)-т зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн 94 дүгээр цэцэрлэг (Б.Алтаннавч)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

В.Оюумаа

В.ОЮУМАА



1150500709

D: lac \BL.Tushaal.docx

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны *[Signature]* дугаар сарын *[Signature]* -ны өдрийн *[Signature]* дугаар тушаалын хавсралт



Бүртгэлд авах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 94 дүгээр цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар, үзүүлэлт	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ		Хандивлагч байгууллага	Хөрөнгийн эх үүсвэр	
							Нэгжийн үнэ	Нийт үнэ			
1	Өсгөгч депузор	Sony MNCY73D	2024	сайн	ш	1	2,699,900.00	2,699,900.00	Багш	Хандив	
2	Зурагт	Neolix NL43	2024	сайн	ш	1	525,000.00	525,000.00	ажилчид		
Тоног төхөөрөмжийн дүн								3,224,900.00			
1	Хивсэн дрож	Хятад	2024	сайн	ш	3	1,500,000.00	4,500,000.00	Эцэг эхчүүд	Хандив	
Тавилга эд хогшлын дүн											
НИЙТ ДҮН									7,724,900.00		